



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 320

Улаанбаатар хот

“Их ирээдүй капитал ББСБ” ХХК-д банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Их ирээдүй капитал ББСБ” ХХК-д банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгосугай.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Их ирээдүй капитал ББСБ” ХХК /Пак Күй Нам/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, холбогдох өөрчлөлтийг Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000902